

**ШИНЖЛЭХ УХААН ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ, БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨТҮГ-ЫН
ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ 2019-2020 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2021 оны 01 дүгээр сарын 29

Багануур дүүрэг

№	Гүйцэтгэх ажлууд	Төлөвлөсөн хугацаа	Биелэлт	Дүгнэлт	Гүйцэтгэл
1.	Багануур үйлдвэрлэл, технологийн паркттай танилцах, хамтран ажиллах хэлэлцүүлэг хийх	2019.05 сар	<ul style="list-style-type: none"> - ШУТИС-ийн дэд захирал Т. Намнан ахалсан 9 хүний бүрэлдэхүүнтэй салбар сургуулиудын удирдах багийг 05.16-ны өдөр Багануурт хүлээн авч, паркийн үйл ажиллагаа болон судалгаа, шинжилгээ хийгдсэн ажлуудын талаар танилцуулга хийж, хамтран ажиллах санамж бичиг байгуулж, хамтын ажиллагааны төлөвлөгөөг батлан, Багануур ХК-ийн уурхайн үйл ажиллагаатай танилцуулах ажлыг зохион байгуулав. - 2020 онд хамтын ажиллагааны төлөвлөгөөний 4, 7 дах арга хэмжээнүүдэд өөрчлөлт оруулсан. 	Цаашид төлөвлөгөөг цар тахалын нөхцөл байдалтай уялдуулан төлөвлөж, инновацийн төслүүдийг хамтран боловсруулах чиглэлээр зорин ажиллана.	100%
2.	БҮТП-ийн үйлдвэрүүдэд хэрэгжиж болохуйц шинэ технологи, патентлагдсан бүтээлийн судалгаа хийх	2019 05, 06 сар	2019 онд ХХААЯ, ХААИС, ШУТИС-аас хамтран гаргасан Хүнс, хөдөө аж ахуйн салбарын шинжлэх ухаан, технологи, инноваци бүтээгдэхүүний 2016 оны эмхэтгэлийг судалж, ШУТИС-ийн эрдэмтэн судлаачдын гаргасан нүүрс брикетлэх, нүүрснээс хагас кокс гаргах технологи зэрэг ирүүлсэн 3 бүтээлийн мэдээллийг үзэж танилцсан.	Цаашид он бүрт патентлагдан гарах шинэ бүтээлийн жагсаалтуудыг нэгтгэн мэдээллийн санг баяжуулна.	100%
3.	Багануурын уурхайн хаягдал түүхий эдэд суурилсан инновацийн бүтээгдэхүүн гаргах судалгаа хийх Үүнд: → Уурхайн хөрсний шорооны хаягдлаас барилгын материал, сэргээгдэх эрчим хүчний чиглэлийн түүхий эд гаргах судалгаа → Уурхайн нүүрс, шорооноос будаг гаргах судалгааны ажил	2 жил	<p>2019 онд дараах арга хэмжээнүүдийг зохион байгуулсан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - БИАС-ийн доктор багш Сүнжидмаагаар ахлуулсан “Багануурын уурхайн хөрсний шорооны хаягдлаас барилгын материал гарган авах” 2014 оны туршилт, судалгааны ажил, ГУУИС-ийн Алтантуяа багшийн удирдсан “Уурхайн хөрсний шороог баяжуулахад ГИБ /Гадаргуугын идэвхит бодис/ ашиглах боломж” судалгааны ажлын тайлангуудыг Багануур ХК-иас авч судлав. - БИАС-ийн доктор Сүнжидмаа багшийн удирдсан багийн хийсэн “Уурхайн шорооноос 	Цаашид инновацийн төслүүдийг хамтран боловсруулах чиглэлээр зорин ажиллана.	100%

			<p>эмульсэн будаг гаргах” судалгаанд тулгуурлан уурхайн хаягдал шорооноос будаг гаргах инновацийн төслийг боловсруулж, ҮХГ-ын GIZ-ЭТИС хөтөлбөрийн 2019 инновацийн төслийн уралдаанд оруулав.</p> <ul style="list-style-type: none"> - Тус сургуулийн багш Алтантуяагийн боловсруулсан Уурхайн нүүрснээс эмэгтэйчүүдийн гоо сайхны будаг гаргах суурь судалгааг явуулах, санхүүжүүлэх хүсэлтийг ШУТИС дэмжин БСШУЯ-нд хүргүүлсэн. <p>2020 онд Олон улсын хамтын ажиллагааны КОЙКА байгууллагын төр хувийн хэвшлийн түншлэлийн хөтөлбөрт уурхайн нүүрснээс шороон будаг гаргах төслийг 2020 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн 22 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.</p> <ul style="list-style-type: none"> - ШУТИС-ийн эрдэмтэд, судлаачдын эрдэм шинжилгээний ажил, шинэ бүтээл болон паркад нэвтрүүлж болохуйц судалгаа бүтээлийг цахим мэдээллийн хэрэгсэл ашиглан судалж байгууллагын мэдээллийн санд нэгтгэх ажлыг зохион байгуулсан. 		
4.	БҮТП-ийн туршилт, судалгааны ажилд ШУТИС-ийн мэргэжлийн лабораториудыг ашиглах боломжоор хангах	2 жил	<ul style="list-style-type: none"> - 2019-2020 онд Дээрх судалгааны ажлуудыг хөрөнгөгүйн улмаас гүйцэтгээгүй. - Мөн онуудад паркийн ЭШСИИТ-ийн засварын санхүүжилтийг улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар шийдвэрлүүлэхээр саналаа хүргүүлж ажилласан. 	Цаашид БИАС, ГУУИС болон МУИС-ийн химийн лабораториудийг түшиглэн судалгааны ажлуудыг гүйцэтгэнэ.	-
5.	БҮТП-ийн инкубатор, инноваци судалгааны төвийн үйл ажиллагаа, томоохон төслүүдэд мэргэжлийн зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулах	Жилдээ	<ul style="list-style-type: none"> - 2019 онд Паркийн захиргаа нь хуучин конторын зориулалттай барилгыг засварлахад - 735 сая төгрөг, тоноглоход шаардлагатай 72 сая төгрөгийн санхүүжилтийг Нийслэлд тавьсан. - 2020 онд засвар, тоног төхөөрөмжийн тооцоог шинэчлэн НШУУИГ, НЗДТГ-т тус тус хүргүүлсэн. 	ПИИСТ-ийн барилгын засвар, тоноглох асуудлыг шийдвэрлүүлсний дараагаар төслийг хэрэгжүүлэхэд эрдэмтэд багш нарын зөвлөгөөг авна.	100%
6.	ШУТИС-ийн судлаачдын бий болгосон оюуны бүтээлийг эдийн засгийн эргэлтэд оруулахад паркаас дэмжлэг үзүүлэх	2 жил	ШУТИС-ийн судлаачдын шинэ судалгаа, бүтээлийн ажлуудыг НШУУИГ, ҮТП-уудтай хамтран зохион байгуулсан уулзалтуудад танилцуулж ажиллаж байна.	Цаашид цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан паркийн хүрээнд хэрэгжүүлэх боломжтой эрдэмтэн багш нарын бүтээлүүдийг	80%

				сурталчилсан уулзалтыг Багануурт хамтран зохион байгуулах хэрэгтэй байна.	
7.	Хамтран боловсруулсан удирдамжийн дагуу БҮТП-д ШУТИС-ийн оюутнуудыг дадлага хийлгэх	Хичээлийн жилээр	Парк оюутнуудыг хүлээн авч, дадлага хийлгэх баазгүй байна.	Цаашдын төлөвлөгөөндөө тусгана.	-
Хэрэгжилтэд тооцох боломжгүй арга хэмжээний тоо					2
Хэрэгжилтийн дундаж хувь					96%

ХЯНАСАН:
БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК
ОНӨТҮГ-ЫН ДАРГА



Ч. ЭЛБЭГСАЙХАН

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:
ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН АЛБАНЫ
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Б.МӨНГӨНХУЯГ

ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН
КЛАСТЕР ИНЖЕНЕР

Э. ЭНХЗАЯА